



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/177

Хэрлэн сум

Согтууруулах ундаа худалдах,  
түүгээр үйлчлэхийг түр хугацаагаар  
хориглосныг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", "л", 29.3, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/167 дугаартай захирамжаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хугацаагаар хориглосныг Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн дэргэдэх эрүүл ахуйн хими хор судлалын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтийн дагуу цуцалсугай.

2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг эрчимжүүлэх, гарсан шийдвэрийг хүргүүлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга /Цагдаагийн хурандаа О.Ганбат/-д, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/-д, харьяалах сумдын Засаг дарга, тосгоны Захирагч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийг олон нийтэд мэдээлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 913